



II/2022

Тархаасан: 2022 оны 4 дүгээр сарын 12




## Гадаад худалдааны нөхцөлийн индекс 2022 оны 2 дугаар сард өмнөх сараас 7.3 хувиар өссөн байна

Гадаад худалдааны нөхцөлийн индекс (2015=100, туршилт тооцоогоор) 2022 оны 2 дугаар сард 179.3 болж, өмнөх оны эцсээс 3.5 хувиар буурсан байна. Харин өмнөх оны мөн үеэс 9.0 хувь, өмнөх сараас 7.3 хувиар тус тус өссөн байна.

Экспортын үнийн индекс (2015=100, туршилт тооцоогоор) 2022 оны 2 дугаар сард 208.2 болж, экспортын үнэ өмнөх оны эцсээс 3.8 хувиар буурсан байна. Харин өмнөх оны мөн үеэс 24.5 хувь, өмнөх сараас 11.4 хувиар тус тус өссөн байна. Экспортын үнийн индекс өмнөх оны эцсээс 3.8 хувиар буурахад эрдэс бүтээгдэхүүний бүлгийн үнэ 20.9 хувиар (төмрийн хүдэр, зэсийн баяжмал, чулуун нүүрс) буурсан нь голлон нөлөөлсөн байна. Харин өмнөх оны мөн үеэс 24.5 хувиар өсөхөд эрдэс бүтээгдэхүүний бүлгийн үнэ 28.4 хувиар (зэсийн баяжмал, чулуун нүүрс, түүхий нефть) өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Импортын үнийн индекс (2015=100, туршилт тооцоогоор) 2022 оны 2 дугаар сард 116.2 болж, импортын үнэ өмнөх оны эцсээс 0.3 хувиар буурсан байна. Харин өмнөх оны мөн үеэс 14.2 хувь, өмнөх сараас 3.8 хувиар тус тус өссөн байна. Импортын үнийн индекс өмнөх оны эцсээс 0.3 хувиар буурахад эрдэс бүтээгдэхүүний бүлгийн үнэ 1.8 хувиар (нефть, цахилгаан эрчим хүч) буурсан нь голлон нөлөөлсөн байна. Харин өмнөх оны мөн үеэс 14.2 хувиар өсөхөд эрдэс бүтээгдэхүүний бүлгийн үнэ 39.8 хувиар (нефть) өссөн нь голлон нөлөөлсөн байна.

ЗУРАГ 1. ГАДААД ХУДАЛДААНЫ НӨХЦӨЛИЙН ИНДЕКС<sup>1</sup> (2015=100), хувь



<sup>1</sup> Туршилт тооцоо

## Ойлголт, тодорхойлолт

Монгол Улсын гадаад худалдааны нөхцөлийн индексийг экспортын үнийн ерөнхий индексийг импортын үнийн ерөнхий индексэд харьцуулж тооцно.

**Экспортын үнийн индекс:** Монгол Улсын экспортын голлох худалдааны түнш орнуудад нийлүүлж буй барааны үнийн нэгдсэн индексийг ойлгоно.

**Импортын үнийн индекс:** Монгол Улсын худалдааны түнш орнуудаас импортолж буй гол нэрийн барааны үнийн нэгдсэн индексийг ойлгоно.



**Суурь үе:** Индекс тооцоход хугацааны бусад үеийн үзүүлэлтэд харьцуулж тооцох хугацаа юм.

## Эх үүсвэр:

Гаалийн ерөнхий газар

## Ангилал:

Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем

## Мэдээлэл авах холбоос:

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

## Дараагийн мэдээ тархаах хуваарь:

2022 оны 5 дугаар сарын 15

Эдийн засгийн статистикийн газрын  
дарга А.Дэмбэрэл  
Утас : (976-11)-329271

Эдийн засгийн статистикийн газрын  
статистикч Д.Мөнхтуул  
Утас : (976-51)-261559



/StatisticMGL



information@nso.mn



1900-1212